

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.БАТЦЭРЭНГИЙН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Боловсролын салбарын хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах.							
1	Арга хэмжээ 1.1 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2025-2026 оны хичээлийн жилийн хамран сургах тойргийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна.	Хэрэгжилтийн хувь	100%	100%	-	03	05
2	Арга хэмжээ 1.2 Сургуулийн өмнөх боловсролд 2-5 насны хүүхдүүдийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.	СӨББ-д хамрагдсан хүүхдийн тоо	26067 хүүхэд	-	2-5 насны нийт хүүхэд	08	09
3	Арга хэмжээ 1.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах үүрэг бүхий "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	ЕБС-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	765 хүүхэд	-	800 хүүхэд	01	12
4	Арга хэмжээ 1.4 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг шинэчилж, саналыг нийслэлийн Боловсролын газарт хүргүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	-	100%	-	03	05

Зорилт 2. Боловсролын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих.							
1	Арга хэмжээ 2.1 Сургууль, цэцэрлэгт тулгарч буй асуудлыг шийдвэрлэх талаар санал, дүгнэлтийг холбогдох байгууллагад уламжилна.	Хэрэгжилтийн хувь	-	100%	100%	01	12
2	Арга хэмжээ 2.2 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулна.	Шуурхай зөвлөгөөний тоо	4	2-оос доошгүй	2-оос доошгүй	01	12
3	Арга хэмжээ 2.3 Дүүргийн зорилтот бүлгийн 2-5 насны хүүхдүүдийг халамжийн 28 дугаар цэцэрлэгт хамруулна.	Хамрагдсан хүүхдийн тоо	150 хүүхэд	-	150 хүүхэд	09	12
4	Арга хэмжээ 2.4 Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Их нүүдэл" шатрын тэмцээнийг зохион байгуулна.	Хамрагдсан сурагчдын тоо	600 сурагч	-	600 сурагч	09	12
5	Арга хэмжээ 2.5 Сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд ур чадварын тэмцээнийг холбогдох хэлтэс, албадтай хамтран зохион байгуулна.	Хамрагдсан багш нарын тоо	3798 багш	1000 багш	2000 багш	01	12
6	Арга хэмжээ 2.6 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад байгалийн ухааны төрөлжсөн кабинет байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	Кабинетын тоо	1 кабинет	3-аас доошгүй	3-аас доошгүй	01	12
7	Арга хэмжээ 2.7 Төрийн өмчийн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд байгалийн ухааны хичээлээр олимпиад зохион байгуулна.	Зохион байгуулсан олимпиадын тоо	3 олимпиад	2-оос доошгүй	2-оос доошгүй	01	12
Зорилт 1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын талаарх хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавин тайлагнана.							
1	Арга хэмжээ 1.1 Хүүхдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий зөвлөлүүдийг шинэчилж, үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	-	100%	100%	01	12
2	Арга хэмжээ 1.2		3 удаагийн сургалт			01	12

	Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалтын тоо		2-оос доошгүй сургалт	2-оос доошгүй сургалт		
3	Арга хэмжээ 1.3 Сургууль, цэцэрлэгийн орчинд эрсдэлийн үнэлгээ хийж, хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулна.	Үнэлгээний тоо	1 удаагийн эрсдэлийн үнэлгээ	-	1 удаагийн эрсдэлийн үнэлгээ	01	12
4	Арга хэмжээ 1.4 “Зөв хүүхэд-Зөв ирээдүй” дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо	42 төсөл, арга хэмжээ	10-аас доошгүй төсөл, арга хэмжээ	10-аас доошгүй төсөл, арга хэмжээ	01	12
5	Арга хэмжээ 1.6 Монгол Улсын Иргэний андгай өргөх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулна.	Ёслолын үйл ажиллагаанд хамрагдсан сурагчдын тоо	120 сурагч	-	100-аас доошгүй сурагч	11	12
6	Арга хэмжээ 1.7 Дүүргийн Засаг—даргын нэрэмжит “Хүүхдийн-урлагийн Их наадам”-ыг зохион байгуулна.	Оролцсон байгууллага, сурагчдын тоо	—	-	50-иас доошгүй байгууллагын 1000 хүртэлх сурагч	3	4
7	Арга хэмжээ 1.8 Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан хагас өнчин, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот өрхийн хүүхдүүдэд баярын бэлэг олгоно.	Зорилтот өрхийн хүүхдийн тоо	2500 хүүхэд	-	2500-аас доошгүй хүүхэд	5	6
Зорилт 2. “Төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр хамтын ажиллагааны санал боловсруулах, гэрээ байгуулах.”							
1	Арга хэмжээ 2.1 Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дүгнэлт, холбогдох материалыг үндэслэн үрчлэлт, асран хамгаалал, харгалзан дэмжигчээр тогтоох захирамжийг боловсруулна.	Захирамжийн тоо	-	50-иас доошгүй захирамж	50-иас доошгүй захирамж	01	12


2	Арга хэмжээ 2.2 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	Хяналт шалгалтын тоо	1 удаагийн хяналт шалгалтад 5 өдөр өнжүүлэх, 8 хүүхэд харах төв	1 удаагийн хяналт шалгалт	1 удаагийн хяналт шалгалт	01	12
3	Арга хэмжээ 2.3 Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, зөвлөлийн тоог нэмэгдүүлнэ.	Эцэг эхийн зөвлөл байгуулсан байгууллагын тоо	98 ААНБ, 58 сургууль, 126 цэцэрлэг	Зөвлөлийн тоог 5-аас дээш тоогоор нэмэгдүүлнэ.	Зөвлөлийн тоог 5-аас дээш тоогоор нэмэгдүүлнэ.	01	12
Зорилт 3. “Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.”							
1	Арга хэмжээ 3.1 Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, ажилтан, албан хаагчид, тэдний гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан үйл ажиллагаа хамрагдсан албан хаагчдын тоо	-	1 удаагийн үйл ажиллагаанд 50-иас доошгүй албан хаагч	1 удаагийн үйл ажиллагаанд 50-иас доошгүй албан хаагч	01	12
2	Арга хэмжээ 3.2 Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	Судалж шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлын тоо	-	60-аас доошгүй албан бичиг, 2-оос доошгүй өргөдөл, гомдол	60-аас доошгүй албан бичиг, 2-оос доошгүй өргөдөл, гомдол	01	12
3	Арга хэмжээ 3.3 Баримт бичгийг архивын стандартад нийцүүлэн хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэн өгнө.	Хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо	-	5-аас доошгүй хадгаламжийн нэгж хүлээлгэн өгнө.	-	01	03
4	Арга хэмжээ 3.4 Ажлын цаг ашиглалтыг баримталж, нийслэл, дүүргээс зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй хамрагдана.	Хэрэгжилтийн хувь	-	100%	100%	01	12

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 2.1 Дээд шатны байгууллага, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалтад идэвхтэй хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	-	3-аас доошгүй сургалтад хамрагдана.	3-аас доошгүй сургалтад хамрагдана.	01	12
2	Арга хэмжээ 2.2 Албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөн явуулна.	Гүйцэтгэлийн хувь	-	100%	100%	01	12

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



(Ч.АРИУНЖАРГАЛ)

2025.02.03

Д. Батцэрэн (Д.БАТЦЭРЭН)

2025.02.03

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Д.БАТЦЭРЭНГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дуусан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1.Боловсролын салбарын хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах							
1	Арга хэмжээ 1.1 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2025-2026 оны хичээлийн жилийн хамран сургах тойргийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна.	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/201 дүгээр захирамжаар төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2025-2026 оны хичээлийн жилийн хамран сургах тойргийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025-2026 оны хичээлийн жилийн хамран сургах тойргийн саналын төсөл хэлэлцүүлэх уулзалтыг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, хамран сургах тойргийн саналын нэгтгэлийг Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. Нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн "Хамран сургах тойрог тогтоох тухай" А/57, А/58 дугаар тушаалын дагуу 2025-2026 оны хичээлийн жилийн элсэлт зохион байгуулагдсан.	2025.03.20 2025.09.30	100%
2	Арга хэмжээ 1.2 Сургуулийн боловсролд 2-5 өмнөх насны хүүхдүүдийг бүрэн	СӨББ-д хамрагдсан хүүхдийн тоо	26067 хүүхэд	27000 хүүхэд	Нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны А/57 дугаар тушаалын хүрээнд төрийн өмчийн цэцэрлэгийн элсэлтийг хамран сургах тойргийн дагуу Имонголиа цахим системээр зохион байгуулсан. 2025-2026 оны	2025.08.01 2025.12.31	100%

	хамруулах ажлыг зохион байгуулна.				хичээлийн жилд тус дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 136 цэцэрлэгт 27884 хүүхэд хамрагдаж байна. Төрийн бус өмчийн 92 цэцэрлэгт 8492 хүүхдийг хамруулсан бөгөөд бүх хүүхдийг цэцэрлэгт хамруулах ажил 100 хувьтай хэрэгжсэн.		
3	Арга хэмжээ 1.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах үүрэг бүхий "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	ЕБС-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	765 хүүхэд	800 хүүхэд	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/193 дугаар захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд холбон зуучлах үүрэг бүхий "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Зөвлөлийн бүрэлдэхүүн 2025 оны 5, 10 дугаар сард хуралдаж, 2025-2026 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах ажлын төлөвлөгөө, тайланг хэлэлцсэн. 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 156, ерөнхий боловсролын сургуульд 588 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, нийт 744 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байсан бол 2025-2026 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 242, ерөнхий боловсролын сургуульд 680 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, нийт 902 хүүхэд хамрагдаж байна. Боловсролын Дэлхийн түншлэл GPE Олон Улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-ийн хүрээнд арга зүйн болон чадавхжуулах сургалтад 15, 118 дугаар сургуулийн 1 багш согог зүйч мэргэжлээр, 19 багш давтан, 17 сурагч хамрагдсан. "Сурагчдыг тэгш хамруулан сургах, хөгжүүлэх арга зүй" сургалтад 32, 34, 89 дүгээр сургуулийн 150 багш хамрагдсан.	2025.02.03 2025.12.31	100%
4	Арга хэмжээ 1.4 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг	Хэрэгжилтийн хувь	-	100%	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/158 дугаар тушаалаар батлагдсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-	2025.02.03 2025.11.18	90%

	шинэчилж, саналыг нийслэлийн Боловсролын газарт хүргүүлнэ.				ын дагуу тус дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 26 сургууль, 45 цэцэрлэгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, батлуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхэд бэлтгэсэн.		
Зорилт 2. Боловсролын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих							
1	Арга хэмжээ 2.1 Сургууль, цэцэрлэгт тулгарч буй асуудлыг шийдвэрлэх талаар санал, дүгнэлтийг холбогдох байгууллагад уламжилна.	Хэрэгжилтийн хувь	-	100%	Хан-Уул дүүргийн 25 дугаар хорооны 243 дугаар цэцэрлэгийн хойд талд баригдаж буй барилгын ажлын явцад хүүхдэд учирч болзошгүй эрсдэлийг арилгуулах талаарх хүсэлтийг Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03/723 дугаар албан бичгээр Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. Хяналт шалгалтын газраас "Цац үйлс" ХХК-д Барилгын техникийн Улсын ахлах байцаагчийн 2-13-01/026/20 дугаартай зөвлөмжийг өгч, зөрчил дутагдлыг арилгуулж, биелэлтийг хангах үүрэг чиглэлийг өгсөн. -Хан-Уул дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт "Барилга байгууламжийн ашиглалт, орчны аюулгүй байдлыг хангах, инженерийн дэд бүтцийн аюулгүй ажиллагааг сайжруулах нь" сэдэвт сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгууллаа. Тус сургалтаар сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн ашиглалтын байдал, инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагаа, хүүхдийн орчны аюулгүй байдалтай холбоотой зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн ашиглалтын талаарх хууль, нормативын шаардлагыг танилцуулсан. Дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тулгамдаж буй асуудлаар ирүүлсэн санал, хүсэлтийг тухай бүр холбогдох хэлтэс, албадад уламжилж ажилласан.	2025.02.03 2025.12.31	100%

2	Арга хэмжээ 2.2 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулна.	Шуурхай зөвлөгөөний тоо	4	2-оос доошгүй	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарын 5 удаагийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулсан. Шуурхай зөвлөгөөнд төрийн өмчийн 26 сургууль, 45 цэцэрлэгийн удирдах ажилтнууд оролцсон ба сургууль, цэцэрлэгт тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, санал хүсэлтийг холбогдох хэлтэс, албадад уламжлан шийдвэрлүүлсэн.	2025.02.03 2025.12.31	100%
3	Арга хэмжээ 2.3 Дүүргийн зорилтот бүлгийн 2-5 насны хүүхдүүдийг халамжийн 28 дугаар цэцэрлэгт хамруулна.	Хамрагдсан хүүхдийн тоо	150 хүүхэд	150 хүүхэд	2025-2026 оны хичээлийн жилд тус дүүргийн 25 хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэр, нөхцөл байдлын үнэлгээ болон холбогдох бусад материалыг үндэслэн 2-5 насны бүтэн өнчин, хагас өнчин, зорилтот өрхийн нийт 135 хүүхдийг халамжийн 28 дугаар цэцэрлэгт хамруулсан.	2025.02.03 2025.12.31	100%
4	Арга хэмжээ 2.4 Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Их___нүүдэл" шатрын тэмцээнийг зохион байгуулна.	Хамрагдсан сурагчдын тоо	600 сурагч	600 сурагч	(Төсвийн хязгаарлалттай холбоотойгоор тус тэмцээн зохион байгуулагдаагүй.)	-	-
5	Арга хэмжээ 2.5 Сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд ур чадварын тэмцээнийг холбогдох хэлтэс, албадтай хамтран зохион байгуулна.	Хамрагдсан багш нарын тоо	3798 багш	3000 багш	Төрийн болон төрийн бус өмчийн 134 цэцэрлэгийн сургуулийн өмнөх боловсролын мэргэжлийн багш нарын ур чадварын уралдааныг 3 үе шаттайгаар зохион байгуулж, нийт 800 гаруй багшийг хамруулсан. Нийт 9 бүсээс шалгарсан 14 багш нар заах арга зүй, бүтээлч байдал, ур чадвараа сорин өрсөлдсөнөөс Тэргүүн байранд "Монгол билиг Оюу" цэцэрлэгийн багш С.Ариунтуяа, 46 дугаар цэцэрлэгийн багш А.Баярмаа, 27 дугаар цэцэрлэгийн багш С.Мөнхбаатар, Дэд байранд "Эрхий мэргэн" цэцэрлэгийн багш Г.Өнөр-эрдэнэ, 41 дүгээр цэцэрлэгийн багш У.Ууганцэцэг, 322 дугаар цэцэрлэгийн багш Л.Мөнхцэцэг, Гуравдугаар байранд "Орчлон" цэцэрлэгийн багш Э. Сувдмаа, 49 дүгээр цэцэрлэгийн багш Х.Батжаргал, 121 дүгээр цэцэрлэгийн багш Ж.Соёнмандах нар тус тус шалгарсан.	2025.02.03 2025.12.31	70%

6	Арга хэмжээ 2.6 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад байгалийн ухааны төрөлжсөн кабинет байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	Кабинетын тоо	1 кабинет	6 кабинет	Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсаны дагуу дүүргийн төсвийн 440.0 сая төгрөгийн хөрөнгөөр 7, 32 дугаар сургуульд байгалийн ухааны лаборатори, 118, 130 дугаар сургуулийн хими, гадаад хэл, монгол хэлний кабинет, 26 дугаар сургуульд мэдээлэл технологийн лаборатори анги байгуулах төсөл арга хэмжээ хэрэгжсэн.	2025.02.03 2025.02.28	90%
7	Арга хэмжээ 2.7 Төрийн өмчийн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд байгалийн ухааны хичээлээр олимпиад зохион байгуулна.	Зохион байгуулсан олимпиадын тоо	3 олимпиад	4 олимпиад	2025-2026 оны хичээлийн жилд улсын төрөлжсөн олимпиадыг дүүргийн хэмжээнд 12 судлагдахуунаар зохион байгуулсан. Төрөлжсөн олимпиадад тус дүүргийн 3854 сургагч, 361 багш хамрагдсан. (Дүүргийн Засаг даргын нэрэмжит олимпиад төсвийн хязгаарлалттай холбоотойгоор зохион байгуулагдаагүй.)	2025.09.01 2025.12.31	70%
Зорилт 1. Хөдөлмөр эрхлэлт, залуучуудын хөгжлийн талаарх хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах							
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр "Таны бүртгэл-Цогц мэдээлэл" төслийг дүүргийн хэмжээнд хариуцан хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	-	100%	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд 2025 оныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан "Таны бүртгэл-Цогц мэдээлэл" төслийг Улсын хэмжээнд 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Төслийн 1 дүгээр үе шатыг цахим хэлбэрээр, 2 дугаар үе шатыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс биечлэн тодруулах аргаар зохион байгуулсан. Төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх сонирхол, хэрэгцээ шаардлага, хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээлийг нарийвчлан судлах зорилго бүхий бүртгэл, судалгааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөс өгсөн чиглэлийн дагуу хөгжлийн	2025.11.01 2025.12.05	95%

					бэрхшээлтэй 408 иргэний гэрт очиж мэдээллийн сан бүрдүүлж ажилласан. Тус судалгааны ажлыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн 1 албан хаагч, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 8 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 95 хувийн гүйцэтгэлтэйгээр хийж гүйцэтгэсэн.		
Зорилт 3. “Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх”							
1	Арга хэмжээ 3.1 Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, ажилтан, албан хаагчид, тэдний гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан үйл ажиллагаа хамрагдсан албан хаагчдын тоо	-	1 удаагийн үйл ажиллагаанд 50-иас доошгүй албан хаагч	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/38 дугаар тушаалаар Засаг даргын Тамгын газар болон хороодын ажилтан, албан хаагчдын хүүхэд, гэр бүлд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, хүүхдэд ээлтэй байгууллага, хамт олныг бий болгоход дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Байгууллагын Эцэг эхийн зөвлөлөөс 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, 11 арга хэмжээний хүрээнд төлөвлөн хэлэлцэж батлуулсан. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд зориулсан хүүхдийн баярын арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр нийслэлийн ерөнхий боловсролын 75 дугаар сургуулийн урлаг танхимд нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан ба тус арга хэмжээнд Засаг даргын Тамгын газрын 50 гаруй ажилтан, албан хаагчдын 100 гаруй хүүхэд багачууд оролцсон.	2025.03.17 2025.05.31	100%
2	Арга хэмжээ 3.2 Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	Судалж шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлын тоо	-	60-аас доошгүй албан бичиг, 2-оос доошгүй	-Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр нийт 164 албан бичиг ирснийг 100% судалж шийдвэрлэсэн. 47 албан бичгийг харилцагч байгууллагуудад хүргүүлсэн.	2025.01.02 2025.12.31	100%

				өргөдөл, гомдол	-Өргөдөл гомдол 6 ирснийг хуулийн хугацаанд судалж шийдвэрлэн, иргэнд хариу өгч ажилласан.		
3	Арга хэмжээ 3.3 Баримт бичгийг архивын стандартад нийцүүлэн хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэн өгнө.	Хүлээлгэн өгсөн хадгаламж- ийн нэгжийн тоо	-	5-аас доогүй хадгала мж-ийн нэгж	Байгууллагын 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгаалал, боловсролын чиглэлээрх 15 хадгаламжийн нэгжийг стандартын дагуу бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэн өгсөн.	2025.01.02 2025.03.30	100%
4	Арга хэмжээ 3.4 Ажлын цаг ашиглалтыг баримталж, нийслэл, дүүргээс зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй хамрагдана.	Хэрэгжилтийн хувь	-	100%	Ажлын цаг ашиглалтыг баримталж, нийслэл, дүүргээс зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцсон.	2025.01.02 2025.12.31	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Арга хэмжээ 1.1 Хүүхдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий зөвлөлүүдийг шинэчилж, үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	-	100%	Хүүхдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий дараах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын захирамжаар шинэчлэн баталсан. Үүнд: -Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд шаардлагатай тусламж үзүүлэх чиг үүрэг бүхий "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо" (Дүүргийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/191 дүгээр захирамж) Тус хорооны 2025 оны төлөвлөгөөг 5 зорилго, 12 зорилтын хүрээнд батлуулж, 81,6 хувьтай хэрэгжсэн. -Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааг хангах салбар дундын зохицуулах чиг үүрэг бүхий "Хүүхдийн	2025.02.03 2025.12.31	70%

					төлөө зөвлөл" (Дүүргийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/194дүгээр захирамж) Тус зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт 63 хувьтай хэрэгжсэн.		
2	Арга хэмжээ 1.2 Сургууль, цэцэрлэгийн орчинд эрсдэлийн үнэлгээ хийж, хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулна.	Үнэлгээний тоо	1 удаагийн эрсдэлийн үнэлгээ	1 удаагийн эрсдэлийн үнэлгээ	Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг үндэслэн 64 сургуульд 2025 оны 1 дүгээр улиралд дотор болон гадаад орчны эрсдэлийн үнэлгээг хийхэд эрсдэлгүй 32, бага эрсдэлтэй 6, дунд эрсдэлтэй 4 сургууль үнэлэгдэж, зөрчлийг арилгуулж ажилласан. Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/218 дугаар тушаалын дагуу дэд ажлын хэсэг 2025.10.20-ны өдрөөс ажиллаж, ерөнхий боловсролын 37 сургуулийн гадна ба дотор орчны стандартын эрсдэлийг үнэлсэн. Тус үнэлгээгээр өндөр эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 5, бага эрсдэлтэй 31 сургууль байна. Өндөр болон дунд эрсдэлтэй сургуулиудад эрсдэл бууруулах ажлын төлөвлөгөө гарган ажиллах үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын баг орчны эрсдэлийн үнэлгээг улирал бүр зохион байгуулж хэвшсэн. 2025 онд хөндлөнгийн үнэлгээг 2 удаа, өөрийн үнэлгээг 4 удаа зохион байгуулсан.	2025.02.03 2025.12.31	100%
3	Арга хэмжээ 1.3 "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо	42 төсөл, арга хэмжээ	20 төсөл, арга хэмжээ	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/114 дүгээр захирамжийн дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн 4 зорилт 32 арга хэмжээний хүрээнд 25 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тив, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн уралдаанд оролцох эрх авсан 10 сурагчийн замын зардалд дэмжлэг үзүүлсэн.	2025.02.03 2025.12.01	100%

					Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зорилтот өрхийн 3250 хүүхдэд баярын бэлэг олгож, дүүргийн хэмжээнд хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 5000 гаруй хүүхэд, багачууд эцэг эх, асран хамгаалагчдын хамт оролцсон. Хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 7 сургууль, 12 цэцэрлэгт сургалтын хэрэглэгдэхүүн, зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн дэмжлэг үзүүлсэн. Хятад, Монголын хүүхэд, залуучуудын нөхөрлөлийн ой байгуулах арга хэмжээнд нийслэлийн ерөнхий боловсролын 15, 18, 52 дугаар сургуулийн 20 сурагч хамрагдсан.		
4	Арга хэмжээ 1.4 Монгол Улсын Иргэний андгай өргөх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулна.	Ёслолын үйл ажиллагаанд хамрагдсан сурагчдын тоо	120 сурагч	120 сурагч	Монгол Улс Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны 101 жилийн ой, Хан-Уул дүүргийн түүхт 60 жилийн ойг тохиолдуулан тусгаар тогтнолын үнэ цэнийг таниулах, эх оронч үзэл, иргэний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, түүх, соёлоо дээдэлсэн иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор "Монгол Улсын Иргэний үнэмлэх гардуулах, иргэний андгай өргөх ёслолын үйл ажиллагаа"-г 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Хан-Уул дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй 16 нас хүрсэн 60 сурагч оролцсон. Ерөнхий сайдын ивээл дор 2025 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан "Монгол Улсын Иргэний андгай өргөх" ёслолын үйл ажиллагаанд тус дүүргээс 90 сурагч оролцсон.	2025.11.01 2025.12.15	100%
5	Арга хэмжээ 1.5 Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хүүхдийн урлагийн Их наадам"-ыг зохион байгуулна.	Оролцсон байгууллага, сурагчдын тоо	-	50-иас доошгүй байгууллагын	"Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн 4.2.2 дахь зорилтын хүрээнд тус дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт суралцаж буй хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн	2025.11.10 2025.12.10	100%

				1000 сурагч	хөгжүүлэх, соёл урлагаар дамжуулан гоо зүйн боловсрол олгох, харилцан суралцах, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор "Хүүхдийн урлагийн Их наадам"-ыг 2025 оны 12 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан. Тус наадамд төрийн болон төрийн бус өмчийн өрөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд бэлтгэл, бага, дунд, ахлах насны ангиллаар 14 номинацид 1500 гаруй хүүхэд оролцсон.		
6	Арга хэмжээ 1.6 Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан хагас өнчин, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот өрхийн хүүхдүүдэд баярын бэлэг олгоно.	Зорилтот өрхийн хүүхдийн тоо	2500 хүүхэд	2500 хүүхэд	-Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн хүрээнд тус дүүргийн зорилтот өрхийн хүүхдүүдэд бэлэг олгох төслийг хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөл болон Засаг даргын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралд тус тус танилцуулж, Засаг даргын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийн дагуу 3250 хүүхдэд бэлэг олгосон. -Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/255 дугаар захирамжаар хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг тус дүүргийн 8 дугаар хороонд байрлах "Степпе Арена" төвийн гадна талбайд 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 11:00-17:00 цагт нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд хүүхэд багачуудад зориулсан урлаг соёлын тоглолтууд, спортын тэмцээн уралдаан, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн танин мэдэхүйн болон хүүхэд хөгжлийн үйл ажиллагаануудыг зохион байгуулсан ба тус арга хэмжээнд нийт 5000	2025.05.01 2025.06.01	100%

					гаруй хүүхэд багачууд, эцэг эх, асран хамгаалагчид оролцсон.		
7	Арга хэмжээ 1.7 Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дүгнэлт, холбогдох материалыг үндэслэн үрчлэлт, асран хамгаалал, харгалзан дэмжигчээр тогтоох захирамжийг боловсруулна.	Гүйцэтгэлийн хувь	-	100%	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дүгнэлт, холбогдох материалыг үндэслэн Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу үрчлэлт, асран хамгаалал, харгалзан дэмжигчээр тогтоох захирамжийн төслийг боловсруулан батлуулсан. (Үрчлэлт-67, асран хамгаалал, харгалзан дэмжигч-24)	2025.02.03 2025.05.30	100%
8	Арга хэмжээ 1.8 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	Хяналт шалгалтын тоо	1 удаагийн хяналт шалгалт	1 удаагийн хяналт шалгалт	Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 43 өдөр өнжүүлэх төв, 8 хүүхэд харах үйлчилгээ бүртгэгдсэн. Иргэдээс гаргасан санал хүсэлт, гомдлын дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн Хүүхдийн эрхийн Улсын байцаагч болон хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтнүүд 11 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.	2025.02.03 2025.12.31	100%
9	Арга хэмжээ 1.9 Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, зөвлөлийн тоог нэмэгдүүлнэ.	Эцэг эхийн зөвлөл байгуулсан байгууллагын тоо	98 ААНБ, 58 сургууль, 126 цэцэрлэг	Зөвлөлийн тоог 5-аас дээш тоогоор нэмэгдүүлнэ.	Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд хамгааллын жишиг бодлогын баримт бичиг", "Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж"-ийн дагуу дүүргийн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын 238 төлөөлөлд байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр 5 удаагийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулсан. Дүүргийн хэмжээнд нийт 237 байгууллага байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлтэй байна.	2025.02.03 2025.12.31	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5

1	Арга хэмжээ 2.1 Дээд шатны байгууллага, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалтад идэвхтэй хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	-	3-аас доошгүй сургалт	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаас зохион байгуулсан дараах сургалтад хамрагдсан. ➢ Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан "Хяналт шинжилгээ хийх", "Үнэлгээ хийх", "Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх" журмын танилцуулга сургалт, ➢ Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Улаан загалмайн хорооноос зохион байгуулсан "Болзошгүй аюулын үед өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэх чадвар олгох" сургалт Удирдлагын академийн "Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт"-д (2025.10.20-2026.01.20) хамрагдаж байна.	2025.01.02 2025.05.30	100%
2	Арга хэмжээ 2.2 Албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөн явуулна.	Гүйцэтгэлийн хувь	-	100%	Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн албан хэргийг хос бичгээр хөтөлж хэвшсэн.	2025.01.02 2025.12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:
БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)



(Д.БАТЦЭРЭН)

(Нэр, гарын үсэг)

2025.12.05

(Огноо)

БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.БАТЦЭРЭНГИЙН
2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН
ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Нийгмийн хөгжлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Боловсролын салбарын хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах					
1	Арга хэмжээ 1.1	58	10	58	
2	Арга хэмжээ 1.2	60	10	70	
3	Арга хэмжээ 1.3	60	10	70	
4	Арга хэмжээ 1.4	55	6	61	
Зорилт 2. Боловсролын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих					
1	Арга хэмжээ 2.1	55	8	63	
2	Арга хэмжээ 2.2	60	10	70	
3	Арга хэмжээ 2.3	60	10	70	
4	Арга хэмжээ 2.4	-	-		
5	Арга хэмжээ 2.5	50	6	56	
6	Арга хэмжээ 2.6	58	8	66	
7	Арга хэмжээ 2.7	50	6	56	
Зорилт 1. Хөдөлмөр эрхлэлт, залуучуудын хөгжлийн талаарх хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах					
1.	Арга хэмжээ 1.1	60	10	70	
Зорилт 3. "Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх."					
1.	Арга хэмжээ 3.1	60	10	70	
2.	Арга хэмжээ 3.2	60	10	70	
3.	Арга хэмжээ 3.3	60	10	70	
4.	Арга хэмжээ 3.4	-	-		
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт					
1	Үүрэг даалгавар 1	50	6	56	
2	Үүрэг даалгавар 2	58	8	66	
3	Үүрэг даалгавар 3	60	10	70	
4	Үүрэг даалгавар 4	60	10	70	
5	Үүрэг даалгавар 5	60	10	70	
6	Үүрэг даалгавар 6	60	10	70	
7	Үүрэг даалгавар 7	60	10	70	
8	Үүрэг даалгавар 8	58	8	66	
9	Үүрэг даалгавар 9	55	6	61	
Дундаж оноо:				66,5	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1		15	
2.	Арга хэмжээ 2		14	
Дундаж оноо			14,5	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	3	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1	6	
7.	Мэргэжлийн ур чадвар 2	6	
8.	Мэргэжлийн ур чадвар 3	6	
Дундаж оноо		6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)


Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 66,5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 14,5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(93 оноо) 93 (6.1)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		95

Үнэлгээ өгсөн:

Нийгмийн хөгжлийн хэлтсийн
ахлах мэргэжилтэн



(Э.БАЯРБАТ)

2025.12.05
..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Боловсролын асуудал
хариуцсан мэргэжилтэн



(Д.БАТЦЭРЭН)

2025.12.05
..... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



(О.МӨНГӨНШАГАЙ)

2025.12.15
..... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөц, хөрөнгө орлогын мэдүүлэг
хариуцсан ахлах мэргэжилтэн



(Б.САРАНЦАЦРАЛ)

2025.12.15
..... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Засаг даргын Тамгын газрын
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч



(З.БУЯНТ)

2025.12.15
..... (огноо)